



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар X/400

Булган сум

**Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.6, 7.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.4.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны XIV дугаар хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны A/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний ерөнхий удирдамжийг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг зохион байгуулахад шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас, 5,350,000 (таван сая гурван зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Тус арга хэмжээг төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

2023 оны 05 сарын 22 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010381

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 22-ны өдрийн А/400 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ УГТАН
“НЭГ ДҮГЭЭРТ ХҮҮХЭД” УРИАН ДОР ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Үндэслэл: Ардчилсан хувьсгалын дараа 1991 оны 1 дүгээр сарын 24-нд Улсын Бага Хурлаас баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн “Нийтээр амрах баярын өдөр” гэсэн 32 дугаар зүйлийн 3-т “Эх үрсийн өдөр 6 дугаар сарын 1” гэж анх хуульчилснаар 1995 онд “Эх үрсийн баяр”, 2003 онд “Хүүхдийн баяр” хэмээн нэрлэн, бүх нийтийн амралтын өдөр болгон өнгөрүүлж байна.

Харамсалтай нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас сүүлийн жилүүдэд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй, өргөн хүрээнд тэмдэглэсэнгүй.

НҮБ-ын Ерөнхий ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг 1959 оны 11 дүгээр сарын 20-нд, “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ыг 1989 оны 11 дүгээр сарын 20-нд баталжээ. Түүнд дэлхийн хамгийн олон буюу 191 орон нэгдэн орсны дотор Монгол Улс 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орсон байна. Энэ конвенцын үзэл санаанд нийцүүлэн УИХ-аас “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийг 1996 онд баталжээ.

Зорилго: Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, хүүхдийг эрүүл аюулгүй, хамгаалагдсан орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачилгыг өрнүүлж, “Нэг дүгээрт хүүхэд” уриа дор эрүүл цэвэр орчинд баяр ёслолыг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд багачуудаа баярлуулах явдал юм.

Хамрах хүрээ, хугацаа: Булган сумын нийт хүүхэд багачуудыг хамруулан 2023 оны 06 сарын 01-ний 10:30-18:00 цагийн хооронд “Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн”-д тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

Зохион байгуулагчид: АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Булган сумын ЗДТГ, Сайхан монгол ТВ.

Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:

- Алдарт эхийн одон гардуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулах
- Хүүхдийн төлөө зөвлөлийн өргөтгөсөн хурал, зөвлөгөөн зохион байгуулах
- Баярын арга хэмжээний нэгдсэн хөтөлбөр гаргах
- Булган аймгийн урлагийн 100 шилдэг хүүхдүүдийн номеруудаас бүрдсэн гала тоглолт зохион байгуулагдах
- Хүүхдүүдэд зориулсан өртөөчилсөн тэмцээн, уралдаан зохион байгуулах (Соёл амралтын хүрээлэн)
- Нэгдсэн арга хэмжээний үеэр хүүхдэд зориулсан үзэсгэлэн худалдааг зохион байгуулах
- Нэгдсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх
- Авто машингүй өдөр арга хэмжээг зохион байгуулах
- “Хүүхэд эрхэм хэрэглэгч” Хүүхдийн худалдааны гудамж ажиллуулах
- Байгууллага бүр гадна орчноо цэвэрлэж, чимэглэх

-----ООо-----

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 22-ны өдрийн А/410 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт
1	2	3	4	5
Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд өгөх гарын бэлэг				
1.	Урлагийн шилдэг хүүхдүүдийн гарын бэлэг бэлдэх	100ш	40,000	4,000,000
2.	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн гарын бэлэг бэлдэх	100ш	40,000	4,000,000
3.	Тайз дэлгэц зөөх	4 талдаа	250,000	500,000
Дүн				8,500,000
Хоёр. 2023 оны 06 сарын 01-нд шинээр мэндэлсэн хүүхдэд өгөх гарын бэлэг				
1.	Нярайн багц (сүүлний тос, цацлага, саван, шампунь)	5 ш	70,000	350,000
2.	Памперс (30ш)			
3.	Бэлэг			
Гурав. Нэгдсэн арга хэмжээнд шаардлагатай хэрэглэгдэхүүн				
1.	Тайз чимэглэх шаар (боронзон, метал 2 өнгөтэй)	1000ш	500	500,000
Нийт			9,350,000	
Үүнээс:				
4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас, 5,350,000 (таван сая гурван зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс,				